



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019 о.д. 22 № 05/1613
танай 2019.02.18 ны № 1/191 -Т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
О.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Handwritten signature

Handwritten notes:
М. Сүрэндэмийн
ашиг зориулалт
Хувийн хэргийн

Handwritten signature and date:
2019.02.28

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Монтооны Сэрсэндэмидийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу тус албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллагын албан тушаалтанд гаргаж мэдүүлэх үүрэгтэй бөгөөд тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР *Х.ХАШБААТАР*



0002987